



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 17 өдөр

Дугаар А/812.

Ховд

Багц болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны “Жагсаалт батлах, эрх шилжүүлэх тухай” А/18 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Улсын төсвийн санхүүжилтээр Ховд аймагт Зам, тээврийн хөгжлийн яамнаас эрх шилжиж ирсэн “Нүүдлийн авто замын засвар, арчлалтын ажил” 120 000 000 төгрөг /нэг зуун хорин сая/-ийн өртөг бүхий ЗТХЯ/2022103036 дугаартай ажлын тендерийг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зарлахдаа газар зүйн байрлалыг харгалзан дараах багц болгосугай. Үүнд:

1. Нүүдлийн авто замын засвар, арчлалт /Мянгад сум/ 1 дүгээр багц - 20.0 сая
2. Нүүдлийн авто замын засвар, арчлалт /Үенч сум/ 2 дугаар багц - 20.0 сая
3. Нүүдлийн авто замын засвар, арчлалт /Дуут сум/ 3 дугаар багц - 20.0 сая
4. Нүүдлийн авто замын засвар, арчлалт /Ховд сум/ 4 дүгээр багц - 20.0 сая
5. Нүүдлийн авто замын засвар, арчлалт /Булган сум/ 5 дугаар багц - 20.0 сая
6. Нүүдлийн авто замын засвар, арчлалт /Буянт сум/ 6 дугаар багц - 20.0 сая

2. 2021 оны 05 дугаар сарын 20-ны дотор батлагдсан төсөвт өртөгт нь багтаан барилга угсралтын гүйцэтгэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, аймгийн Засаг даргын дэргэдэх Худалдан авах ажиллагааны албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Батсүх/ нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг хариуцан ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ